

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНДЭСЛЭЛГҮЙ
ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар3
Баян-Өлгий аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Дарга, тэргүүлэх аудитор	Бүлэг 1
М.Хуанган	1.Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн талаар
Аудитын менежер	1.1 Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн талаар 5-8
Х.Женисбек	1.2 Тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн төлөвлөлтийн талаар 9-10
Аудитор	Бүлэг-2
М.Айнур	2.Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар
Х.Манаргүл	2.1 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 10-13
Д.Назгул	Бүлэг -3
Б.Үүрийнтуяа	3.Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар
2017 оны 4 дүгээр сар	3.1 Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн талаар 14-15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930 дугаарын утас, 70422954 дугаарын факсаар харилцана уу	3.2 Орон нутгийн төсвийн суурь зарлагын гүйцэтгэлийн талаар 15-17
ХАЯГ:	3.3.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар 17-18
Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар	3.3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаар 17-19
	3.4 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар 18-19
	3.5 Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлийн талаар 19-21
	3.6 Тусгай зориулалтын шилжүүлгийн нэмэлт санхүүжилтийн талаар 21-22
	Дүгнэлт..... 32
	Зөвлөмж.....33
	Холбогдох байгууллагын санал:
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
	Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Баян-Өлгий аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Баян-Өлгий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтыг дэвшүүллээ.Үүнд:

- Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг
- Орлогын гүйцэтгэл
- Зарлагын гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актыг холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа.Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитын хамрах хүрээ:

ТЕЗ-ийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг аж ахуйн нэгж байгууллага, орон нутгийн өмчит болон оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн тайлан, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын олон улдсын стаандарт, Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг мөрдөж, байгууллагын холбогдох албан тушаалтнуудад ярилцлага хийх, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын судалгаа хийж, шаардлагатай горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж, боловсруулсан.

Бүлэг-1

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн талаар

1.1 Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн талаар

Төсвийн тодотголоор анх батлагдсан орлогын төлөвлөгөө 3,9 хувиар буюу 255,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн XVI хуралдааны 63 дугаар тогтоолоор 2016 оны орон нутгийн төсвийн орлогыг 6527,06 сая төгрөгөөр, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг 11484,5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 4018,0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 45748,7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг 53,1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Орон нутгийн нийт орлогыг 6526,9 сая төгрөгөөр баталсны дотор аймгийн төсвийн орлогыг 6002.1 сая төгрөгөөр, сумын төсвийн орлогыг 524.8 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-аас 2016 онд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд 2 удаа, зарлагын төлөвлөгөөнд 3 удаа өөрчлөлт оруулж тодотгож баталсан байна. /Сумууд татварын орлогод хуулийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж баталсныг нэгтгэж, хамгийн сүүлийн багана дээр нэгтгэж харуулсан/

Үүнийг ОНТГ-Хавсралт №1 хүснэгтээс харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Сангийн ямны хянасан дүн	2016 он				Аймаг, су мдын ИТХ-аас баталсан төсвийн нэгтгэл	Анхлан баталсн аас зөрүү
		Анх батлагд сан	Тодотго л-1	Тодотго л-2	Тодотго л-3		
Б	1	2	3	4	5	6	
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар		2015.12.0 4 №63	2016.03.0 4 №68	2016.06. 06 №71	201.10.07 №08		
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	6,398.10	6,526.90	6,526.90	6,527.00	6,527.00	6,782.40	255.50
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,398.10	6,526.90	6,526.90	6,527.00	6,527.00	6,782.40	255.50
УРСГАЛ ОРЛОГО	6,333.10	6,461.90	6,461.90	6,462.00	6,462.00	6,717.40	255.50
Татварын орлого	5,963.20	6,062.10	6,062.10	6,062.20	6,062.20	6,303.80	241.70
Татварын бус орлого	369.90	399.80	399.80	399.80	399.80	413.60	13.80
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	65.00	65.00	65.00	65.00	65.00	65.00	-
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО							-
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	21,900.60	22,011.50	23,512.60	23,613.9 0	22,908.40	23,988.30	1,976.80
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,882.60	17,993.50	19,494.60	19,484.90	19,630.30	20,580.80	2,587.30
УРСГАЛ ЗАРДАЛ	17,882.60	17,993.50	19,494.60	19,484.90	19,630.30	20,580.80	2,587.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,279.20	7,391.90	8,850.80	8,841.10	8,640.40	9,476.50	2,084.60
ХҮҮ			-		-	-	-
ТАТААС	27.00	25.20	25.20	25.20	25.20	32.70	7.50
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,576.40	10,576.40	10,618.60	10,618.60	10,964.70	11,071.60	495.20
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,018.00	4,018.00	4,018.00	4,129.00	3,278.10	3,407.50	(610.50)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ							-

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

УРСГАЛ ТЭНЦЭЛ	11,484.50	11,484.50	11,466.60	11,466.50	11,608.70	11,626.60	142.10
НИЙТ ТЭНЦЭЛ	15,502.50	15,484.60	16,985.70	15,595.50	16,381.40	17,205.90	1,721.30

1.Аймгийн ИТХ-ын 2016 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 68 дугаар тогтоолоор 2016 оны орон нутгийн төсөвт тодотгол хийснээр орон нутгийн төсвийн орлогод өөрчлөлт оруулаагүй. Харин Сум хөгжүүлэх сангийн төсвийг 2623,6 сая төгрөгөөр нэмж баталж, дараах төсвийн зарлагыг 1728,4 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Үүнд:

- Аймгийн орон нутгийн төсвийн ерөнхий дансны орлогын үлдэгдлээс 1501,1 сая төгрөгийг дахин хуваарилж, орон нутгийн зарлагыг нэмэгдүүлж тодотгосон байна.Үүнд: Төсөвт байгууллагуудын урсгал зарлагад 107,8 сая төгрөгийг /үүнээс цалингийн зардлаас 105,0 сая төгрөгийг/, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт 990,9 сая төгрөгийг, орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн төсөвт 402,4 сая төгрөгийг нэмсэн байна.
- Тухайлбал: 2016 оны төсөв батлахдаа орон нутгийн төсөвт байгууллагуудын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож, үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн 10 хувь хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлтийг 2016 оны төсөвт тусгуулахаар Сангийн яамнаас чиглэл өгсөн байна.
- Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын 2016 оны цалингийн сан, НДШ-ийн хамтаар 554,2 сая төгрөгөөр дутсаны 498,1 сая төгрөг нь цалингийн, 56,1 сая төгрөг нь НДШ-ийн зардал байна.Иймд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс төсөвт байгууллагуудын урсгал зардлыг 10-20 хувиар танаж, урсгал зардлаас 108,6 сая төгрөгийг, 2015 оны ерөнхий дансны үлдэгдлээс 105,0 сая төгрөгийг шилжүүлж, нийт 213,6 сая төгрөгийг цалингийн санд нэмж тодотгосон байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 82,0 сая төгрөгийг, БНХАУ-ын элчин сайдаас буцалтгүй тусламжаар олгосон 29,0 сая төгрөгийг, бүгд дүнгээр 111,0 сая төгрөгийг ОНХ сангийн зарлагад нэмж тодотгож, ОНХС сангийн төсвийг 4129,0 сая төгрөгөөр баталсан байна.
- Сангийн яамнаас сангуудын орлого, зарлагыг төсөвт баталж тусгуулахаар зөвлөмж ирүүлсний дагуу Сум хөгжүүлэх сангийн тухайн жилийн эргэн төлөгдөх зээлийн хэмжээгээр сум хөгжүүлэх сангийн төсвийг 2623,6 сая төгрөгөөр баталсан байна.
- Төсвийн хэмнэлт гаргасан болон өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн орон нутгийн 10 байгууллагад Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн үлдэгдлээс 116,3 сая төгрөгийг төсвийн урамшуулал болгон олгож, төсвийн зарлагыг нэмэгдүүлж, тодотгосон байна.

2.Аймгийн ИТХ-ын 2016 оны 6 дугаар сарын 06-ний өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 71 дугаар тогтоолоор орон нутгийн орлого хооронд, төсөвт байгууллагуудын зардал хооронд дараах зохицуулалтыг хийж, урсгал зарлагыг 105,1 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.Үүнд:

- Орон нутгийн төсвийн цалингийн ашгийн татварыг 119,3 төгрөгөөр нэмэгдүүлж, татварын буцаан олголтонд нэмж баталсан байна./татварын орлогын нийт дүнд өөрчлөлт ороогүй/
- Үйл ажиллагааны орлогыг төсвийн тухай хуулийн 23.8-д заасны дагуу Өлгий сумд байхаар Сангийн яам, Татварын хэлтсээс чиглэл өгсний дагуу 2016 оны 6 сараас үйл ажиллагааны орлогыг Өлгий сумд төвлөрүүлэхээр шийдвэрлэсний дагуу Өлгий сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 192,9 сая төгрөгөөр бууруулж, 387,6 сая төгрөг байхаар баталж, зөрүүг Татварын хэлтэст нэмсэн /нийт санхүүжилтийн дүнд өөрчлөлт ороогүй/ байна.
- Ерөнхий орлогын дансны үлдэгдлээс Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт 15,2 сая төгрөгийг нэмж тодотгосон.
- Биеийн тамир спортын хорооны урсгал зардлын хэмнэлтээс цалингийн зардалд 3,2 сая төгрөгийг, багаж хэрэгсэлд 1,2 сая төгрөгийг шилжүүлж зохицуулалт хийсэн байна.
- Үерийн гамшигтай холбоотой аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 7 сарын 19-ний өдрийн 104 тоот тогтоолоор ОНХ сангийн хөрөнгөнөөс 70,0 сая төгрөгийг, ерөнхий дансны үлдэгдлээс 65,0 сая төгрөгийг, нийт 135,0 сая төгрөгийг гамшгийн зардалд шилжүүлэн зарцуулахаар шийдвэрлэсэн байна.Энэ дагуу ерөнхий дансны үлдэгдлээс 89,9 сая төгрөгийг орон нутгийн нөөц хөрөнгөнд нэмж тодотгосон байна.

3.Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус II дугаар хуралдааны 08 дугаар тогтоолоор орон нутгийн урсгал зарлагыг нийт дүнгээр 698,6 сая төгрөгөөр хасч, зардал хооронд зохицуулалт хийсэн байна.

- Сангийн Яамнаас орон нутгийн татварын орлогыг 109,7 сая төгрөгөөр бууруулан, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлсэн боловч, аймгаас орон нутгийн орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй байна.
- Халамжийн сангийн төсвийг 274,2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
- Тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийг 72,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Орон нутгийн сонгуулийн зардал болох 248,2 сая төгрөгийг СЕХ-нд шилжүүлсэн байсныг орон нутгийн төсвөөс хассан.
- Орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал зардлыг 38,9 сая төгрөгөөр бууруулсан.
- ОНХСангийн төсвийг 758,0 сая төгрөгөөр танасан байна.

Сангийн яамнаас орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг анх 6398,1 сая төгрөгөөр хянасан байна. ИТХ-ын 2015 оны 12 сарын 04-ний хуралдаанаас татварын орлогыг 6526,9 сая төгрөгөөр буюу хянасан дүнгээс 128,8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сангийн яамнаас татварын орлогыг 109,7 сая төгрөгөөр бууруулан, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж тодотгосон боловч, аймгаас ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй байна.Иймд татварын орлогын төлөвлөгөөг 6527,0 сая төгрөг байхаар баталжээ.

Харин сумдын хуулинд заасан эрх хэмжээний хүрээнд татварын давсан орлогыг төсөвт нэмж тодотгосныг аймгийн дүнгээр нэгтгэл хийж үзэхэд аймгийн татварын

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

орлогын төлөвлөгөөг 6782,4 сая төгрөг байхаар төлөвлөгөөнд өөрчлөлт орж, төлөвлөгөө 255,4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр	Анх баталсан төлөвлөгөө	2016 оны тодотгосон төлөвлөгөө	Зөрүү дүнгээр	Хувиар
	Нийт орлого	6526,9	6782,4	255,5	103,9
1	Татварын орлого	6062,1	6303,8	241,7	104,0
2	Татварын бус орлого	399,8	413,6	13,8	103,4
3	Хөрөнгийн орлого	65,0	65,0	-	-

Төсвийн тодотголоор орлогын 92,9 хувийг татварын орлогоос, 6,1 хувийг татварын бус орлогоос, 0,9 хувийг хөрөнгийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2016 он	
		Дүн	Дүн
	Нийт орлого	6782,4	100.0
1	Аймгийн төсөвт орох орлого	6368,8	93,9
2	Сумын төсөвт орох орлого	413,6	6,1

Орон нутгийн 2016 оны төсвийн орлогын 91,9 хувийг аймгийн төсөвт орох орлого, 8,1 хувийг сумын төсөвт орох орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч, сумын тодотгосон төсвийг нэгтгэсэн дүнгээр нийт орлогын 93,9 хувийг аймгийн төсөвт орох орлого, 6,1 хувийг сумын төсөвт орох орлого бүрдүүлсэн байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тодотгосон төсвөөр 2016 оны орон нутгийн төсвийн нийт зарлага 26584,5 сая төгрөг болж, анх батлагдсанаас 4554,9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн зарлагын төлөвлөгөө тодотгосон төсвөөр:

/сая төгрөгөөр/

№	Зарлагын нэр	2016 оны төлөвлөгөө		
		Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Өсөлт, бууралт
	Нийт зарлага	22,029.60	26,584.50	4,554.90
1	Бараа, үйлчилгээний зардал	7,165.20	11,066.60	3,901.40
2	Татаас ба урсгал шилжүүлэг	10,601.60	11,104.30	502.70
3	Хөрөнгө оруулалтын зардал	4262.8	4,413.60	150.80

Тодотгосон төсвөөр бараа үйлчилгээний зардал, урсгал шилжүүлэг, хөрөнгө оруулалтын зардал 150,8-3901.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Аймгийн ИТХурлын тэргүүлэгчдийн тогтоолоор орон нутгийн 2015 оны төсвийн үлдэгдлээс зарцуулсан хөрөнгийг төсвийн зарлагад тусгасантай холбоотой.

Төсвийн зарлагын бүтцийг авч үзэхэд 41.6 хувь нь бараа үйлчилгээний зардал, 41.7 хувь нь татаас ба урсгал шилжүүлэг, 16.7 хувь нь хөрөнгө оруулалтын зардал байна.

1.2 Тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн төлөвлөлтийн талаар

Тусгай зориулалтын шилжүүлэгийн төсөв тодотголоор 887.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийг 2016 онд анх 44868,7 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд төсвийн тодотголоор 46382,9 сая төгрөг болгож, 887,9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Тодотгосон төсвөөр ерөнхий боловсрол, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсвийг 212,1-837,6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сургуулийн өмнөх боловсрол, Нийтийн биеийн тамирийн үйлчилгээний төсвийг 16,1-145,7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн бүтцийг авч үзвэл 66,5 хувийг боловсрол, 19,1 хувийг сургуулийн өмнөх боловсрол, 4,1 хувийг соёлын салбар, 8,5 хувийг эрүүл мэндийн салбар, 1,8 хувийг бусад салбарын төсөв эзэлж байна.

№	Салбарын нэр	/сая төгрөгөөр/			
		Анх баталсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү	Хувь
1	Ерөнхий боловсрол	30,020.30	30,857.90	837.60	102.8
2	Сургуулийн өмнөх боловсрол	8,739.00	8,908.30	-145.7	101.9
3	Соёл үйлчилгээ	1,803.30	1,899.20	-	105.3
4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	3,528.50	3,930.80	212.1	111.4
5	Газрын харилцаа кадастрын үйлчилгээ	255.1	262.2	-	102.8
6	Хүүхэд гэр бүл хүүхэд хамгааллын үйлчилгээ	99.0	98.4	-	99.4
7	Нийтийн биеийн тамирийн үйлчилгээ	423.5	426.1	-16.1	100.6
	Нийт дүн	44,868.70	46,382.90	887,9	103.4

Тусгай зориулалтын шилжүүлгийн батлагдсан төсвийг өнгөрсөн онтой харьцуулж үзэхэд, нийтдээ 3362,1 сая төгрөгөөр буюу 7,8 хувиар нэмэгдсэн байна.

Үүнээс боловсролын салбарын төсөв 8,4 хувиар буюу 2383,0 сая төгрөгөөр, сургуулийн өмнөх боловсролын төсөв 11,2 хувиар буюу 898,1 сая төгрөгөөр, соёлын салбарын төсөв 2,7 хувиар буюу 50,0 сая төгрөгөөр, эрүүл мэндийн салбарын төсөв 1,4 хувиар буюу 53,3 сая төгрөгөөр, газрын харилцаа, кадастрын үйлчилгээний төсөв 3,8 хувиар буюу 9,6 сая төгрөгөөр нэмэгдэж, Хүүхэд гэр бүлийн хамгааллын үйлчилгээний төсөв 14,4 хувиар буюу 16,5 сая төгрөгөөр, Биеийн тамирын үйлчилгээний төсөв 3,5 хувиар буюу 15,4 сая төгрөгөөр буурсан байна.

№	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
		2015 оны төлөвлөгөө	2016 оны төлөвлөгөө	Зөрүү	Хувь
1	Ерөнхий боловсрол	28,474.90	30,857.90	2,383.00	108.4
2	Сургуулийн өмнөх боловсрол	8,010.20	8,908.30	898.10	111.2
3	Соёл үйлчилгээ	1,849.20	1,899.20	50.00	102.7
4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	3,877.50	3,930.80	53.30	101.4
5	Газрын харилцаа кадастрын үйлчилгээ	252.6	262.2	9.60	103.8
6	Хүүхэд гэр бүл хүүхэд хамгааллын үйлчилгээ	114.9	98.4	-16.50	85.6
7	Нийтийн биеийн тамирийн үйлчилгээ	441.5	426.1	-15.40	96.5

Нийт дүн	43,020.80	46,382.90	3,362.10	107.8
-----------------	------------------	------------------	-----------------	--------------

Бүлэг-2

2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар

2.1 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 135,3 сая төгрөгийг суутгасан байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн нийт орлогын гүйцэтгэл 69390,1 сая төгрөгт хүрч өмнөх оноос 3724,3 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Нийт орлогын 6865,2 сая төгрөгийг буюу 9,9 хувийг орон нутгийн төсвийн орлого, 62524,9 сая төгрөгийг буюу 90,1 хувийг тусламж, санхүүжилтийн орлого эзэлж эзэлж байна.

/ сая/төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант он		
		Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	3	4	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	65,665.80	72,967.20	69,390.10	-3,577.10
НИЙТ ОРЛОГО	6,735.60	6,782.40	6,865.20	82.80
УРСГАЛ ОРЛОГО	6,735.60	6,717.40	6,865.20	147.80
Татварын орлого	6,073.90	6,303.80	6,530.50	226.70
Татварын бус орлого	661.7	413.6	334.7	-78.90
ХӨРӨНГИЙН ТУСЛАМЖ		65.0		-65.00
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	58,930.20	66,184.80	62,524.90	-3,659.90
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,816.30	3,407.50	3,412.70	5.20
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	12,952.80	11,548.00	11,491.30	-56.70
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	42,117.60	46,329.80	46,215.90	-113.90

Орон нутгийн орлогын 6530,5 сая төгрөгийг буюу 95,1 хувийг татварын орлого, 334,7 сая төгрөгийг буюу 4,9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Тусламжийн орлогын 3412,7 сая төгрөгийг буюу 5,2 хувийг Орон нутгийн хөгжлийн сангийн орлого, 11491,3 сая төгрөгийг буюу 18,3 хувийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, 46215,9 сая төгрөгийг буюу 66,7 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 1405,0 сая төгрөгийг буюу 2,2 хувийг бусад орлого эзэлж байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө 72967,2 сая төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 69390,1 сая төгрөг зарцуулж, төлөвлөгдсөнөөс 3577,1 сая төгрөгөөр бага зарлага гаргасан байна.Үүнд: татварын орлого 82,8 сая төгрөгөөр давж, тусламж, санхүүжилтийн орлого 3659,9 сая төгрөгөөр тасарсан байна.

Орон нутгийн төсвийн урсгал орлогын төлөвлөгөөг 1,2 хувиар буюу 82,9 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Татварын нийт орлогоос 6782,2 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн урсгал орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогыг оруулж

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

тооцсоноор 6921,8 сая төгрөг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 102,1 хувиар буюу 139,6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогоос төсвийн байгууллагын өөрийн орлогыг хасч тооцвол урсгал орлогын төлөвлөгөө 1,2 хувиар буюу 82,9 сая төгрөгөөр давж биелэгдсэн дүнтэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

	ᠶᠡᠨᠨᠠᠭᠠᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠭ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/ Зөрүү	
				дүнгээр	хувиар
	УРСГАЛ ОРЛОГО	6,782.20	6,865.10	82.90	101.2
	ТАТВАРЫН ОРЛОГО	6,368.70	6,530.40	161.70	102.5
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	413.5	334.7	-78.80	80.9

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг нэмсэн дүнгээр авч үзэхэд татварын орлогоос 6921,8 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 102,5 хувиар буюу 139,6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэлийн нэр төрлөөр авч үзвэл: хувь хүний орлогын албан татвараас 5083,7 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 100,2 хувиар буюу 9,3 сая төгрөгөөр, өмчийн татварын орлогоос 273,8 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 126,3 хувиар буюу 57,0 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний татварын орлогоос 292,4 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 116,0 хувиар буюу 40,4 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөрөөс 468,8 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 120,7 хувиар буюу 80,4 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ

Харин бусад татварын орлогоос 411,7 сая төгрөг оруулж, орлогыг 5,8 хувиар буюу 37,2 сая төгрөгөөр, татварын бус орлогоос 391,3 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 5,4 хувиар буюу 22,2 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

Татварын бус орлогын 14,5 хувь буюу 56,6 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлого, 85,5 хувийг буюу 334,7 сая төгрөгийг хүү, торгууль, бусад орлого эзэлж байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр нэгтгэн харуулбал:

ᠶᠡᠨᠨᠠᠭᠠᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠭ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/ Зөрүү	
			дүнгээр	хувиар
УРСГАЛ ОРЛОГО	6,782.2	6,921.7	139.5	102.1
ТАТВАРЫН ОРЛОГО	6,368.7	6,530.4	161.7	102.5
Орлогын албан татвар	5,074.4	5,083.7	9.3	100.2
ХАОАТатвар	5,074.4	5,083.7	9.3	100.2
ᠣᠠᠭᠡᠢ ᠲᠡᠭᠦᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ ᠠᠭᠡᠢ	5,462.3	5,530.1	67.8	101.2
Үйл ажиллагааны орлого		539.9	539.9	#DIV/0!
ᠶᠡᠨᠨᠠᠭᠠᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠭᠤᠨ	507.7	3.6	(504.1)	0.7
Хувиара аж ахуй эрхэлсний орлогын тадаа	65.0		(65.0)	-
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар		45.7	45.7	#DIV/0!
ШУУЗУБТАЗБүтээх орлогын татвар			-	#DIV/0!

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Шууд бус орлого	2.5	47.0	44.5	1,880.0
Хувиараа бараа материал бэлтгэсний татвар			-	#DIV/0!
ХХОАТатварын буцаан олголт	(963.1)	(1,082.6)	(119.5)	112.4
Өмчийн татвар	216.8	273.8	57.0	126.3
Төрийн өмчийн албан даатгал	150.1	214.7	64.6	143.0
Ажлын хэргийн даатгал	66.7	59.1	(7.6)	88.6
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	252.0	292.4	40.4	116.0
Ажлын хэргийн даатгал	252.0	292.4	40.4	116.0
Бусад татвар	437.1	411.7	(25.4)	94.2
Орлогын даатгал	305.0	266.0	(39.0)	87.2
Ажлын хэргийн даатгал	97.5	115.1	17.6	118.1
Орлогын даатгал	30.0	18.8	(11.2)	62.7
Хог хягдалын үйлчилгээний хураамж	4.6	0.016	(4.6)	0.3
АМБББАОЗЗХураамж		0.5	0.5	
бусад татвар		11.3	11.3	
Байгалийн нөөц ашигласны төлбөр	388.4	468.8	80.4	120.7
Ус, рашаан ашигласны төлбөр	48.0	17.9	(30.1)	37.3
Иргэдийн хэрэглээний татвар, орлогын даатгал	42.6	25.4	(17.2)	59.6
Байгалийн ургамлын НАТөлбөр	297.8	0.5	(297.3)	0.2
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж		425.0	425.0	
II.Татварын бус орлого	413.5	391.3	(22.2)	94.6
Хувьцааны ноогдол ашиг			-	
Хүүгийн орлого		29.3	29.3	
Торгуулийн орлого	250.0	299.7	49.7	119.9
Түрээсийн орлого			-	
Төсөвт газрын өөрийн орлого	51.3	56.6	5.3	110.3
Бусад нэр заагдаагүй орлого	112.2	5.7	(106.5)	5.1
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	-	-	-	-
Хөрөнгө худалдсаны орлого			-	
Өмч хувьчлалын орлого			-	
2.Урьд оны давсан орлогоос санхүүжих			-	

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 1,2 хувиар буюу 135,3 сая төгрөгөөр дутуу олгогдсон нь Засгийн газарт төлөх зээлийг улсын төсвөөс авах дэмжлэгээс хасч олгосонтой холбоотой байна.

ХХОАТатвар нийт дүнгээр 530,6 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна. Үүнээс : цалин, түүнтэй адилтгах орлогын албан татвар 67,8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого буюу орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

орлогын албан татвар 35,7 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар 45,7 сая төгрөгөөр, шууд бус орлогын албан татвар 44,5 сая төгрөгөөр давж биелэгджээ. Өмчийн татвар 64,6 сая төгрөгөөр давж биелэгдсэний дотор үл хөдлөх хөрөнгийн албан татвар 143,0 хувиар давж, бууны албан татвар 11,4 хувиар тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 10,5 хувиар буюу 5,4 сая төгрөгөөр биелэгдсэн боловч өөрийн орлогын төлөвлөгөөг БОАЖГазар 1,7 сая төгрөгөөр буюу 49,3 хувиар тасалсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэгтгэн харуулбал:

№	Сумын нэр	/сая төгрөгөөр/ 2016 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Сумын төсвийн орлого	973.0	1164.3	191.30	119.66
2	Аймгийн төсвийн орлого	5,809.20	5,700.90	(108.30)	98.14
	БҮГД	6,782.20	6,865.20	83.00	101.22

Сумын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 191,3 сая төгрөгөөр буюу 19,6 хувиар давж, аймгийн орлогын төлөвлөгөө 108,3 сая төгрөгөөр буюу 1,86 хувиар тасарсан үзүүлэлттэй байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг Дэлүүн, Цэнгэл, Өлгий сумаас бусад бүх сум 1,9-279,3 хувиар давуулан биелүүлсэн байна. Дэлүүн сумын ангийн орлогоос урьдчилж орсон 38,3 сая төгрөгийг татварын орлогод тооцож ирүүлснийг татварын биелэлтээс хасуулж, сумын ТТЗ-ийн нэгдсэн санхүүгийн тайланд залруулга хийснээр орлогын төлөвлөгөө 20,9 сая төгрөгөөр тасарсан байна.

Дэлүүн сум 20,9 сая төгрөгөөр буюу 12,5 хувиар, Цэнгэл сум 7,9 сая төгрөгөөр буюу 11,9 хувиар, Өлгий сум 1,7 сая төгрөгөөр буюу 0,5 хувиар орлогын төлөвлөгөөг тасалдуулж Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Бүлэг -3

3. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

3.1 Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн талаар

Сум хөгжүүлэх сангийн төсвийн төлөвлөлийг бодитой төлөвлөөгүй байна.

ТЕЗ-ийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийтдээ 69390.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 4,9 хувиар буюу 3577.1 сая төгрөгөөр бага зардал гаргажээ.

Энэ нь сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг олгосон зээлийн хэмжээгээр төлөвлөсөн ба зээлийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байгаатай холбоотой. Мөн Нийгмийн халамжийн сан, ОНХСангийн дутуу санхүүжилт болон ОНХСангийн зарцуулагдаагүй мөнгөний үлдэгдэл байна.

Төсвийн зарлагын нийт эх үүсвэрийн 46215,9 сая төгрөгийг улсын төсвөөс, 21769,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1375,1 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 29,9 сая төгрөгийг тусламжийн орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөгөөтэй харьцуулан авч үзвэл тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих дүн 113,9 сая төгрөгөөр дутуу байгаа нь төсвийн хэмнэлт байна.

Төсвийн зарлагын бүтцийг авч үзвэл нийт төсвийн зарлагын 23146,3 сая төгрөгийг буюу 33,3 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал, 46243,8 сая төгрөгийг буюу 66,6 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага эзэлж байна.

ТЕЗ-ийн нийт төсвийн 52659,8 сая төгрөгийг буюу 75,9 хувийг бараа үйлчилгээний зардалд, 13638,9 сая төгрөгийг буюу 19,6 хувийг урсгал шилжүүлэгийн зардалд, 2738,3 сая төгрөгийг буюу 3,9 хувийг дотоодын хөрөнгө оруулалтанд тус тус зарцуулжээ.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар багцын дүнгээр хүснэгтээр нэгтгэн харуулав. Үүнд:

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант он		Зөрүү
		Төсөв	Гүйцэтгэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,787.30	72967.2	69390.1	-3,577.10
УРСГАЛ ЗАРДАЛ	64,787.30	68553.6	66329.3	-2,224.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,981.10	54153.2	52659.8	-1,493.40
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,792.00	34606.8	34940.6	333.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,739.40	3813.4	3895.6	82.20
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,403.30	4297.1	4344	46.90
Хангамж, бараа материалын зардал	815.9	966.9	974	7.10
Нормативт зардал	3,375.90	4080.1	3962	-118.10
Эд хогшил, урсгал засварын зардал	207.8	252.5	299.8	47.30
Томилолт, зочны зардал	223.5	153.6	166.4	12.80
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308.2	940.8	1401.1	460.30
Бараа үйлчилгээний бусад зардал	2,115.10	5041.9	2676.1	-2,365.80
		32.7	30.6	-2.10
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,339.30	14367.6	13638.9	-728.70
Засгийн газрын урсгал шилжүүлэг	486.3	61.4	61.4	0.00
Бусад урсгал шилжүүлэг	11,853.00	14306.2	13577.5	-728.70
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,466.90	4413.6	2738.3	-1,675.30
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		2626.7	322.5	-2304.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,797.80	72967.2	69390.1	-3,577.10
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,017.30	46329.8	46215.9	-113.90
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	42,017.30	46329.8	46215.9	-113.9

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,457.10	21737,9	21769,2	31,3
Орон нутгийн төсвөөс	18,640.80	18330,4	18356,5	26,1
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,816.30	3407,5	3412,7	5,2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,822.30	4870,5	1375,1	-3495,4
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ		29	29.9	0.90

Батлагдсан төсөвтэй харьцуулбал бараа үйлчилгээний зардал 1493,4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 728,7 сая төгрөгөөр, дотоодын хөрөнгө оруулалт 1675,3 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2304,2 сая төгрөгөөр буюу нийт дүнгээр 3577,1 сая төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

3.2 Орон нутгийн төсвийн суурь зарлагын гүйцэтгэлийн талаар.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2016 оны үйл ажиллагаанд нийтдээ 26,584.5 сая төгрөгийн төсөв батлагдсаны 22063.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4491.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 29,0 сая төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 22742.9 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 599.4 сая төгрөгийн орлогыг, тусламжийн эх үүсвэрээс 29,9 сая төгрөгийг оруулж бүгд дүнгээр 23385,2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 23146,3 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, төлөвлөснөөс 3438,2 сая төгрөгөөр бага зарлага гаргасан байна. Энэ нь тайлант онд Сум хөгжүүлэх сангийн төсвийн төлөвлөгөөг олгосон нийт зээлийн хэмжээгээр төлөвлөж оруулсан боловч гүйцэтгэл нь төлөвлөснөөс бага дүнтэй гарсантай холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/сая төгрөгөөр/ Тайлант он		
		Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	3	4	5=4-3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0	274.1	274.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,646.40	26584.5	23146.3	-3438.2
УРСГАЛ ЗАРДАЛ	22,646.40	21201.6	20089.3	-1112.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,486.20	10097.3	9634	-463.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,935.30	4881.9	4892.8	10.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	553.1	539.8	535.5	-4.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	428.2	456	452.7	-3.3
Хангамж, бараа материалын зардал	341.9	372.6	374.5	1.9
Нормативт зардал	25.9	41.3	33.9	-7.4
Эд хогшил, урсгал засварын зардал	51.8	106.3	97.7	-8.6
Томилолт, зочны зардал	175.7	115.7	122.2	6.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	254.6	1350.2	1117.4	-232.8

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Бараа үйлчилгээний бусад зардал	1719.7	2233.3	2007.1	-226.2
Татаас		32.7	30.6	-2.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9696.4	11071.6	10424.7	-646.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4463.8	2756.2	2734.4	-21.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		2626.7	322.5	-2304.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23999.1	26584.5	23385.2	-3199.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			13	13
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22457.1	22063.9	22742.9	679
Орон нутгийн төсвөөс	18640.8	18776.5	19479.9	703.4

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар багцын дүнгээр авч үзвэл нийгмийн даатгалын шимтгэл 4,3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,3 сая төгрөгөөр, нормативт зардал 7,4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 8,6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 232,8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 226,2 сая төгрөгөөр, татаас 2,1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 646,9 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 21,8 сая төгрөгөөр тус тус хэмнэгдэж, цалин 10,9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1,9 сая төгрөгөөр томилолт, зочны зардал 6,5 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байна. Эргэж төлөгдөх зээлийг хассан цэвэр зээлийн батлагдсан төлөвлөгөө 2304,2 сая төгрөгөөр тасалдсан байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг нэгтгэн харуулбал:

№	Байгууллагын нэр	2016 йн дүн		Үзүүлэлт, /хэмнэлт, хэтрэлт/
		Төлбөр, хураамж	Бусад зардал	
1	Аймгийн ИТХурал	313.7	313.7	0.0
2	Аймгийн ЗДТГазар	1,607.1	1,584.1	-23.0
3	Хот тохижуулах алба	237.2	236.3	-0.9
4	Хэвлэл мэдээллийн алба	174.5	181.9	7.4
5	Замын сангийн хөрөнгө оруулалт	226.8	225.4	-1.4
6	ОНӨ -ийн газар	95.5	117.3	21.8
7	Байгаль орчин аялал жуулчлалын газар	408.0	405.0	-3.0
8	Халамжийн сан	10,762.8	10,096.4	-666.4
9	Асрамжийн газар	90.5	82.9	-7.6
10	Сум дундын ойн анги	52.5	52.5	0.0
11	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1,006.1	967.3	-38.8
12	Орон нутгийн хөгжлийн сан	3393.5	3035.6	-357.9
13	СХДААлба	87.7	87.3	-0.4
14	Мал хамгаалах сан	14.0	15.7	1.7
15	Сум хөгжүүлэх сан	2,626.7	326.8	-2,299.9
16	Алтай сумын орон нутгийн төсөв	354.90	354.90	0.0
17	Алтанцөгц сумын орон нутгийн төсөв	289.50	288.30	-1.2
18	Баяннуур сумын орон нутгийн төсөв	356.90	356.60	-0.3
19	Бугат сумын орон нутгийн төсөв	333.90	333.90	0.0
20	Булган сумын орон нутгийн төсөв	465.20	433.40	-31.8
21	Буянт сумын орон нутгийн төсөв	385.20	385.10	-0.1
22	Дэлүүн сумын орон нутгийн төсөв	564.40	558.60	-5.8
23	Ногооннуур сумын орон нутгийн төсөв	366.60	364.30	-2.3
24	Сагсай сумын орон нутгийн төсөв	348.40	348.30	-0.1

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

25	Толбо сумын орон нутгийн төсөв	344.50	344.40	-0.1
26	Улаанхус сумын орон нутгийн төсөв	455.00	445.30	-9.7
27	Цагааннуур тосгоны төсөв	97.30	97.20	-0.1
28	Цэнгэл сумын орон нутгийн төсөв	431.10	420.60	-10.5
29	Өлгий сумын төсөв	552.40	546.80	-5.6

Хэвлэл мэдээллийн албаны төсөв 7,4 сая төгрөгөөр, ОНӨГазрын төсөв 21,8 сая төгрөгөөр төлөвлөснөөс их дүнтэй гарч, бусад сум, орон нутгийн байгууллагууд төлөвлөснөөс бага зардал гаргажээ. Мал хамгаалах сангийн төсөв 1,7 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байгаа нь мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдлийг зарцуулсантай холбоотой.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжинд 10762,8 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 10,096.4 сая төгрөгийг зарцуулж төлөвлөснөөс 666.4 сая төгрөгөөр бага зарлага гарчээ. Жилийн эцэст Нийгмийн халамжийн сангийн арилжааны банкинд байгаа харилцах дансны үлдэгдлээс 146,7 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

3.3 Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар

3.3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Аймгийн ИТХ-ын 2016 оны 71 тоот тогтоолоор 2015 оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжүүлэн 2016 онд хэрэгжүүлэхээр 854,7 сая төгрөгийн өртөг бүхий 26 төсөл арга хэмжээг, ирэх онд хэрэгжих ТАХ-ний зураг төсвийн зардал, тусламжийн хөрөнгийн тээврийн зардал, гадаадын тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний орон нутгийн оролцоо зэрэг зардлуудад 151,4 сая төгрөг нийтдээ 1006,1 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын чиглэлээр зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь данснаас 827,6 сая төгрөгийг хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтээр олгож, 137,1 сая төгрөгийг батлагдсан төсвийн дагуу бусад зардалд зарцуулж, оны эцэст дансны үлдэгдэл 41,8 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Олгосон санхүүжилт:

а. 2016 онд БСШУСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын дагуу 841.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.

б. ЭМСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас 2016 онд нийтдээ 267,7 сая төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан.

в. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрх шилжүүлсэний дагуу 49,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэний дагуу нийтдээ 1158,8 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудад ажлын гүйцэтгэлээр олгожээ.

3.3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаар

Аймгийн ИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн XVI дугаар хуралдааны 63 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийн нийт дүнг 4018.0 сая төгрөгөөр баталжээ. Үүнээс сумдын ОНХСанд 2009.0 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 2009.0 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилсан байна.

Төсвийн тодотголоор ОНХНСангаас авах орлогын шилжүүлгийг 3278.1 сая төгрөгөөр баталж, аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс 127.4 сая төгрөгийг, бусад орлогоос 152.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, ОНХСангийн орлогын нийт дүнг 3558.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь анх батлагдсан төсвөөс 459.9 сая төгрөгөөр буюу 11.4 хувиар буурсан байна. Үүнээс сумын ОНХСанд 1726.6 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 1831.5 сая төгрөгийн хөрөнгийг олгохоор хуваарилсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Тодотгосон төлөвлөгөө
ОНХНэгдсэн сангаас хуваарилах орлого	3278.1
Аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс хуваарилсан хөрөнгө	127.4
Аж ахуйн нэгж, байгууллагад олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлого	152.6
Нийт дүн	3558.1
Үүнээс: Сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	1726.6
Аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	1831.5

ОНХ сангийн орлогын бүрдүүлэлт, олголтын байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Санхүүжилтийн эх үүсвэр	/сая.төг/	
	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл
ОНХСангийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл	127.4	127.4
Орлого		3412.7
ОНХНэгдсэн сангаас хуваарилагдсан хөрөнгө	3278.1	3260.1
2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс	9.9	9.9
ААНбайгууллагад илүү олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлого	29.6	29.6
Цэнгэл сумын төсөлд эргэж төлөгдөх нөхцлөөр олгосон хөрөнгө	80.0	80.0
БНХАУлсын Алтай аймгаас олгосон хандив	30.0	30.0
Бусад	3.1	3.1
ОНХСангийн нийт эх үүсвэр	3558.1	3540.1
Сумын ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	1726.6	1280.1
Аймгийн ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	1831.5	1829.5
Эцсийн үлдэгдэл		430.0

ОНХ сангийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл нь 127,4 сая төгрөг ба 3412,7 сая төгрөгийг орлогыг оруулж, аймгийн болон сумын ОНХ санд 3109,6 сая төгрөгийг хуваарилан олгож, 2016 оны жилийн эцэст 430,0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдсэн байна.

3.4 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн байгууллагууд нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн байгууллагууд 1478,5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилийн зарцуулалтыг харуулбал:

		/ сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		Гүйцэтгэл	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1478.5	100
УРСГАЛ ЗАРДАЛ		1478.2	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1461.9	98.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		41.9	2.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		0.7	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		0.4	0.0
Хангамж, бараа материалын зардал		3.3	0.2
Нормативт зардал		5.3	0.4
Эд хогшил, урсгал засварын зардал		8.4	0.6
Томилолт, зочны зардал		8.9	0.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		142.7	9.7
Бараа үйлчилгээний бусад зардал		1250.2	84.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		16.2	1.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.3	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1478.5	100.0
Нэмэлт санхүүжилтийн орлого		1478.5	100.0

Нэмэлт санхүүжилтийн зарлагын бүтцийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 2,9 хувийг буюу 42,6 сая төгрөгийг, бараа үйлчилгээний урсгал зардалд 84,6 хувийг буюу 1250,2 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 9,7 хувийг буюу 142,7 сая төгрөгийг, бусад зардлуудад 1,8 хувийг буюу 26,3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн данснаас нийтдээ 2,2 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлжээ.

3.5 Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлийн талаар.

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 191,7 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

ТЕЗ-ийн Тусгай зориулалтын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар авч үзвэл тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2016 оны үйл ажиллагаанд нийтдээ 46382,9 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Санхүүжүүлэх эх үүсвэрийг авч үзвэл 46329,8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 51,5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,5 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 46203,0 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 35,8 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 6,2 сая төгрөгийн орлогыг оруулан бүгд дүнгээр 46244,9 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, төлөвлөснөөс 138,1 сая төгрөгөөр бага зарлага гаргасан байна. Оны эцэст 1,3 сая төгрөгийн зарцуулагдаагүй мөнгөний үлдэгдэлтэй байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын харилцах данснаас оны эцэст нийтдээ 191,7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үүнд: Боловсрол, соёлын салбарын байгууллагуудаас 90,5 сая төгрөгийг, Эрүүл мэндийн байгууллагуудаас 6,7 сая төгрөгийг, Соёлын төвүүдээс 11,3 сая, Хүүхдийн цэцэрлэгүүдээс 11,5 сая, Биеийн тамир, спортын газраас 11,3 сая, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 60,2 сая төгрөгийг, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсээс 0,1 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 51,5 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 1,5 сая төгрөгийн нийт 53,1 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө өгөгдсөнөөс үндсэн үйл ажиллагаанаас 35,8 сая төгрөгийн, туслах үйл ажиллагаанаас 6,2 сая төгрөгийн нийт 42,0 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 20,9 хувь буюу 11,1 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг салбараар нь нэгтгэн харуулбал:

/сая төгрөгөөр/					
Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ЕБСургуулиуд	30,707.9	30,619.1	-88.8	0.3
2	СТөвүүд	1,899.2	1,878.3	-21.0	1.1
3	ХЦэцэрлэгүүд	9,058.3	9,046.1	-12.2	0.1
4	ЭМСалбарууд	3,930.8	3,926.0	-4.8	0.1
5	БТСХороо	426.1	414.7	-11.5	2.7
6	ХГБХХэлтэс	98.4	98.3	-0.1	0.1
7	ГХБХБГазар	262.2	261.5	-0.7	0.3
	Нийт дүн	46,382.9	46,243.8	-139.1	0.3

Боловсрол, соёлын салбарын байгууллагууд 88,8 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 4,8 сая төгрөгөөр, Соёлын төвүүд 21,0 сая төгрөгөөр, Хүүхдийн цэцэрлэгүүд 12,2 сая төгрөгөөр, Биеийн тамир, спортын газраас 11,5 сая төгрөгөөр, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар 0,7 сая төгрөгөөр, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс 0,1 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарчээ.

Төсвийн гүйцэтгэлийг багц дүнгээр зардлын зүйл ангиар авч үзвэл дараах байдалтай байна.Үүнд:

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/ Тайлант оны		Зөрүү	хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,382.9	46,243.8	139.10	0.3
УРСГАЛ ЗАРДАЛ	46,382.9	46,240.0	142.93	0.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,138.1	43,025.9	112.24	0.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,013.9	30,047.8	(33.87)	-0.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,307.4	3,360.1	(52.74)	-1.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,874.8	3,891.3	(16.50)	-0.4
Хангамж, бараа материалын зардал	574.6	599.5	(24.92)	-4.3
Нормативт зардал	4,111.3	3,928.1	183.23	4.5
Эд хогшил, урсгал засварын зардал	145.5	202.1	(56.51)	-38.8

Баян-Өлгий аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Томилолт, зочны зардал	36.6	44.2	(7.59)	-20.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	295.8	283.8	12.07	4.1
Бараа үйлчилгээний бусад зардал	778.0	669.0	109.02	14.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,245.0	3,214.2	30.75	0.9
Бусад урсгал шилжүүлэг	3,245.0	3,214.2	30.75	0.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3.8	(3.84)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,382.9	46,244.9	138.01	0.3
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	46,329.8	46,203.0	126.89	0.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51.5	35.8	15.76	30.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1.5	6.2	(4.64)	-301.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.2	(0.18)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1.3	(1.30)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	109	109	-	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,989	4,099	(110.00)	-2.8

Нийт төсвийн 72,2 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 20,9 хувийг бараа үйлчилгээний зардалд, 6,9 хувийг нийгмийн хамгааллын зардалд зарцуулсан байна.

Тайлант онд нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, урсгал шилжүүлгийн зардлыг 30,7-183,2 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарч, цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа үйлчилгээний зардал, эд хогшил авах, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, хөрөнгийн зардлыг 3,8-56,5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

3.6 Тусгай зориулалтын шилжүүлгийн нэмэлт санхүүжилтийн талаар

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагууд тайлант онд нийтдээ 803,8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авснаас боловсрол, соёлын салбарын байгууллагууд 194,8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 192.0 сая төгрөгийн, Соёлын салбар 20.6 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгүүд 1,5 сая төгрөгийн, БТСХороо 13,6 сая төгрөгийн, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс 381,3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилийн орлогыг салбараар нь нэгтгэн харуулбал:

/ сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Тайлант он	Хувь
1	ЕБСургуулиуд	194.8	24.2
2	СТөвүүд	20.6	2.6
3	ХЦцэцэрлэгүүд	1.5	0.2
4	ЭМСалбарууд	192.0	23.9
5	БТСХороо	13.6	1.7

6	ХГБХХэлтэс	381.3	47.4
Нийт дүн		803.8	100.0

Нэмэлт санхүүжилтийн зарлагын бүтцийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 3,5 сая төгрөгийг, нормативт зардалд 0,2 сая төгрөгийг, хангамж, бараа материалын зардалд 29,1 сая төгрөгийг, эд хогшил, урсгал засварын зардалд 14,9 сая төгрөгийг, томилолтын зардалд 1,8 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 284,3 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 284,7 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 157,1 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 25,5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн данснаас 4,1 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилийн зарцуулалтыг зардлын ангилалаар нь харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	803.8	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	779.6	97.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	618.7	77.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3.5	0.4
Хангамж, бараа материалын зардал	29.1	3.6
Нормативт зардал	0.2	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	14.9	1.9
Томилолт, зочны зардал	1.8	0.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284.3	35.4
Бараа үйлчилгээний бусад зардал	284.7	35.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157.1	19.5
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4.1	0.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25.5	3.2
Дотоод эх үүсвэрээр	25.5	3.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	803.8	
Нэмэлт санхүүжилтийн орлого	803.8	

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Төсвийн тодотголоор анх батлагдсан орлогын төлөвлөгөө 3,9 хувиар буюу 255,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
2. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 135,3 сая төгрөгийг суутгасан байна.
3. Орон нутгийн төсвийн урсгал орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 1,2 хувиар буюу 82,9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч Татварын хэлтэс, зарим сум төлөвлөгөөг тасалсан байна.
4. Орон нутгийн төсвийн суурь зарлага төлөвлөснөөс 3438,2 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарахад Сум хөгжүүлэх сангийн төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн нь нөлөөлсөн байна.
5. Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагууд төсвөө бүрэн авсан байна.
6. Нэмэлт санхүүжилтийг зориулалтаар нь зарцуулсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1.Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг оновчтой төлөвлөж, орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах, хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах;

2.Төсвийн зарлагын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах;

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

АУДИТОР

Х.МАНАРГҮЛ

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА